

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-17

-
1. **Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 3-17

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
07 дугаар сарын 02-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 15 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга;

Тасалсан: П.Батчимэг, Х.Ганхуяг, Б.Найдалаа, О.Цогтгэрэл, Д.Энхтүвшин.

Нэг.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга Г.Эрхэмбаяр, Эрчим хүчний сайдын зөвлөх Б.Нямаа, Д.Лхамаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Ж.Алдаржавхлан, М.Мандхай, Ж.Ганбаатар, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, М.Энхцэцэг, Р.Сэддорж, Б.Жаргалан нар үг хэлэв.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, *Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Жаргалан* ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./13:08/

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 53 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
12 цаг 15 минут.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая . Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Бадамсүрэн, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батшугар, Бямбасүрэн, Ганбаатар, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Найдалаа, Энхцэцэг нарын гишүүд оролцож байна. Гишүүдийн хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 72 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Улсын Их Хурлын гишүүн Жаргалан ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн танилцуулна. Сайдын микрофоныг нээе. 5 номер.

Б.Чойжилсүрэн: Эрхэм байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд төрөөс эрчим хүчний салбарын өсөлтийг дэмжин либералчлал хийх асуудлыг тусгасны дагуу эрчим хүчний томоохон төслүүдийг нэн даруй эхлүүлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд дунджаар 7-12 хувиар өсөж байна. Энэ хэрэглээний өсөлтийг хангах дотоодын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх нөөц чадлын зохистой хэмжээнд хүрэх буюу 20 хувиар илүү байх, одоо байгаа суурилагдсан хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, 2030 оны түвшинд 3750мвт хүрэх хэрэгцээ шаардлага үүсжээ.

Эрчим хүчний төслүүд нь санхүүжилтийн хувьд асар өндөр өртөгтэй бөгөөд үүнийг төр дангаар санхүүжүүлэх боломжгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зайлшгүй шаарддаг. Гэвч санхүүжилтийн дүнгээс хамаарч хөрөнгө оруулагч орж ирэхэд хүндрэлтэй төслүүдэд төрөөс тодорхой хэсгийг санхүүжүүлэх шаардлага үүсэж байна. Энэ тохиолдолд төрийн санхүүжилттэй холбоотойгоор эрчим хүчний төслийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах зайлшгүй шаардлага үүсэж байна. Тухайлбал, төрөөс төслийн тодорхой хэсгийг нь санхүүжүүлээд, үлдэх төлбөрийг нь тухайн станцын үйл ажиллагааны орлогоос нь буцаан төлөх ЕРС нэмэх нь F нөхцөлтэй сонгон шалгаруулалт хийх боломж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Төр, хувийн хэвшлийн тухай хуулиудаар харилцааг зохицуулах боломжгүй байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн өнөөгийн зохицуулалтын хүрээнд сонгон шалгаруулах тохиолдолд ЕРС нэмэх нь F буюу барих шилжүүлэх төслийг хэрэгжүүлэхийг хориглосон. Түншлэлийн бусад хэлбэрээр шалгаруулах бол 36-48 сарын хугацаа шаардагдах нөхцөл байдалтай байна.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар түлхүүр гардуулах нөхцөлтэй буюу инженеринг, прокурмент, констракшн гэрээгээр сонгон шалгаруулалт зарлах боломжгүй болсон. Нөгөө талаас ЕРС нэмэх нь F төслийн санхүүжилтийн зарим хэсгийг гүйцэтгэгч нь санхүүжүүлэх нөхцөлтэй бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар тендер сонгон шалгаруулалт зарлах боломжгүй байна.

Иймээс Төрийн болон орон нутгийн өмчид эзэмших эрчим хүчний томоохон төслүүдийг яаралтай хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бий болгох шаардлагын хүрээнд эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй уялдуулан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах эрх, сонгон шалгаруулалтын нөхцөл шаардлагыг тогтоох харилцааг зохицуулна. Сонгон шалгаруулалтыг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ. Сонгон шалгаруулалт хийх ажлын хэсэгт тавигдах шаардлагыг хуулийн төсөлд тодорхойлсон ба энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан үнэлгээний хороотой ижил нөхцөл, шаардлага хангасан гишүүдтэй байна.

Түүнчлэн түлхүүр гардуулах нөхцөлөөр сонгон шалгаруулалт хийхтэй холбоотойгоор туслан гүйцэтгэгчийн чадавхын үнэлгээнд тооцох асуудлыг хуулийн төсөлд тусгалаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж төсөл сонгон шалгаруулах замаар эрчим хүчний эх үүсвэр барих этгээдийг тодорхойлж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор хувийн хэвшилтэй хамтран ажиллах хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байна.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулах харилцааг Төр, хувийн хэвшлийн тухай хуулиар зохицуулах бөгөөд нэгэнт шалгаруулалт хийсэн төслийн хувьд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн процессыг хялбаршуулах, сонгон шалгаруулж гэрээ байгуулах хугацааг богиносгох харилцааг зохицуулахаар тусгалаа.

Мөн төрийн болон орон нутгийн өмчид эзэмших эрчим хүчний төслүүдийн хувьд төслийн санхүүжилтийн хэлбэр, төрийн оролцооноос хамааран и пи си менежмент хийх, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх, барьж шилжүүлэх менежмент, санхүүжилт болон барих шилжүүлэх төрлүүдийг зайлшгүй нэмэх шаардлагатай байна.

Дагаж гарах хуулийн төслөөр Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Тодруулбал, эрчим хүчний үнэ тарифыг төрөөс хянаж ирсэнтэй холбоотойгоор төрийн өмчит аж ахуйн нэгжүүд алдагдалтай ажиллаж ирсэн бөгөөд Засгийн газрын баталгааны шаардлагыг хангаж чадахгүй нөхцөл байдалд байна.

Мөн эрчим хүчний барилга байгууламжийн төсөл нь түлхүүр гардуулах буюу инженеринг, прокурормент, констракшн хэлбэрээр хэрэгждэг бөгөөд төслийн нарийвчилсан зураг төсөл нь төслийн явцад хийгддэг. Хэрэв өрийн удирдлагын тухай хуулийн одоогийн зохицуулалтын дагуу нарийвчилсан зураг төслийг урьдчилан хийх тохиолдолд технологи болон үйлдвэрлэгчийг урьдчилан сонгож өрсөлдөөнийг хязгаарлах маш өндөр зардал гаргаж зураг төслийг урьдчилж хийх зэрэг үр дагавар гарахаар байна. Иймд хуулийн төслөөр эрчим хүчний төслийн хувьд гаргах Засгийн газрын өрийн баталгааны хувьд тавигдах шаардлагыг өөрчилж, нарийвчилсан зураг төсөв шаардахгүй байх, сүүлийн 3 жил ашигтай ажилласан байх шаардлагыг бууруулж, төсөл нь санхүүжилтээ эргэн нөхөх санхүүгийн тооцоотой байхаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсрууллаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төр, хувийн хэвшил хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан эрчим хүчний эх үүсвэр шинээр барьж байгуулан, эрчим хүчний үйлдвэрлэл найдвартай байдлыг дээшлүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх ба сонгон шалгаруулалтад оролцогчид нь эрчим хүч нийлүүлэх үнэ, хэмжээ, станцыг төрд хүлээлгэн өгөх хугацаагаар харилцан өрсөлдөж, хамгийн сайн үнэлгээтэй төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах юм.

Улсын Их Хурлын байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Гансүхийн Эрхэмбаяр Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга, Баяртогтохын Нямсүрэн Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, Буянтогтохын Нямаа Эрчим хүчний сайдын орон тооны зөвлөх, Дансрангийн Лхамаа Эрчим хүчний сайдын орон тооны бус зөвлөх.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Жамбалын Ганбаатар гишүүнээр тасалъя. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Тэгээд ажлын хэсэг гараад бас тал талаас нь үзэж хараад шийднэ биз. Ерөнхий энэ улс орны эдийн засгийг суурь хөгжлийн асуудал ерөөсөө л эрчим хүчний эх үүсвэр хангалттай, хүртээмжтэй, найдвартай байгаа эсэхээс л шалтгаална. Өнөөдрийн бараа үйлчилгээний бодит өртөгт нөлөөлдөг хамгийн том зүйл бол тээвэр логистикийн зардлаас гадна эрчим хүчний үнэ тарифын асуудал байгаа. Тэгэхээр бид хэд ер нь зүгээр улс юм бол эрчим хүчний тусгаар тогтнолын асуудлыг яг бодитой ярьж, улс төржихгүйгээр урагшлахгүй бол одоо 20 жилийн өмнөх гэдэг юм уу ийм домог мэтийн яриа ярьсаар л байна. Одоо 5 дугаар цахилгаан станцын домог сонсогдоод л. Би өнөөдөр яг 40 настай. Хамгийн сүүлд яг эрчим хүчний эх үүсвэрийг 1984 онд буюу намайг яг төрж байхад барьж байсан юм байна лээ. Үүнээс хойш ерөөсөө юм баригдсангүй. Өмнөговьд бол тухайн компанийн хэрэгцээг хангах 20мвт-ынх байх шиг байна. Дулааны эрчим хүчний эх үүсвэр бол Амгалангийнхаас өөр юм бараг алга. Тэгээд үндсэндээ энэ асуудлуудыг бас зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байгаа учраас энэ хуулийг бол дэмжиж байна. Тэгэхээр энэ эрчим хүчний эх үүсвэрүүдийн насжилт, найдвартай ажиллагааны байдал ер нь Монгол Улсад хэр байна вэ гэдэг дээр хариулт өгөөч. Олон нийтэд мэдээллийг хүргэмээр байгаа юм.

2 дугаарт эрчим хүчний эх үүсвэрт холбогдъё гэдэг хүсэлт зөвхөн орон сууцын нийтийн зориулалттай орон сууц байдаг юм уу. Үүнээс гадна аж ахуйн нэгж, байгууллагуудын үйлдвэрлэлийн хэмжээ буюу хэрэгцээ хэр ингэж өсөж ирчхээд, тулчхаад та хэд энийг нь холбох асуудлыг нь шийдэхгүй байж байгаа вэ.

Дээрээс нь энэ эрчим хүчний асуудлаас шалтгаалаад тодорхой төслүүдтэй ч уяж байсан эрчим хүчний төслүүд байгаа. Жишээ нь Тавантолгой. Тавантолгойн энэ станцыг бид нар барьж чадахгүйгээс шалтгаалаад жишээ нь хэчнээн төгрөгийн валютыг жилд алдаж байгаа вэ. Энэ асуудлуудыг бас нэг хариулж өгөөч.

Тэгээд эцэст нь би бас нийслэлээс сонгогдсон гишүүний хувьд ер нь Улаанбаатар хот бас эрчим хүч, дулааны асуудал бас хүндэрч байгаа. Энэ Тэц-3 дээр осол гарсны улмаас. Энэ хотын хүн амыг 100 хувь гэх үү эсвэл барилгыг 100 хувь л үзвэл хэчнээн хувь нь энэ нөхцөл байдалд өртөхөөр байгаа вэ. Энийг өвлөөс өмнө ямар хариу арга хэмжээ авахаар Засгийн газар ажиллаж байгаа юм бэ. Бас олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор асууж байгаа юм. Тэгээд бид хэд яг бодит үнэнээ яриад, шийдэл арга замаа хайгаад, хяналтаа тавиад урагшлахгүй бол асуудлууд ужгирсаар байна, хүндэрсээр байгаа гэдгийг бол хаана хаанаа ойлгож байгаа. Тэгээд энэ 4 асуултад бас товчхон олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор бас яг тоон үзүүлэлтээр нь хариулж өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд хариулъя. 5 Номер.

Б.Чойжилсүрэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын хэмжээнд өнөөдөр 5 эрчим хүчний систем хоорондоо холбогдоогүй үйл ажиллагаа явуулж байгаа. Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний систем, Төвийн бүсийн эрчим хүчний систем, Зүүн бүсийн эрчим хүчний систем гээд. Өмнөд бүсийн эрчим хүчний систем төвийн бүсийн эрчим хүчний системийг бид нар 330 киловольтын цахилгаан дамжууллагаар шугамаар холбоод одоо 4 станцтай

байгаа. Төвийн бүсийн эрчим хүчний систем дээр яг өнөөдрийн байдлаар 1264 мвт-ын 6 дулаан цахилгаан станц үйл ажиллагаа явуулж байгаа. Тэц-3, Тэц-4, Тэц-2, Дарханы дулааны станц, Эрдэнэтийн 2 дулааны станц байгаа. Ийм байдалтай. Эдгээр 1264 Мвт маань яг өвлийн оргил ачаалалтайгаар ямар ч нөөцгүйгээр бүх тоноглолоо ажиллуулахад 1101 Мвт-ыг төвийн эрчим хүчний системд дотоод хэрэглээнийхээ асуудалд нийлүүлж байгаа ийм байдалтай явж байгаа. Үүнээс 226 мвт-ын хүчин чадалтай труба генераторууд бол ашиглалтын хугацаа дуусчихсан ийм байдалтай байгаа.

Хувийн салбараас төвийн бүсийн эрчим хүчний системд 2 станц залгагдан ажиллаж байна. Бөөрөлжүүтийн цахилгаан станцын эхний блок 150 Мвт-ын блокийг өнгөрсөн жилийн 12 сард холбосон. Энэ жилдээ багтаагаад 150 Мвт-ын 2 дахь блокийг холбох ийм тооцоотой. Түүнээс гадна Завхан аймгийн Тосонцэнгэл сум дээр 30 Мвт-ын цахилгаан станцын 21 Мвт-ын хүчин чадалтай эхний 2 блокийг холбож байна. Энэ жилдээ багтаагаад Сэлэнгэ аймгийн төв дээр Райт Монголиа гэдэг компани 70 Мвт-ын хүчин чадалтай ДЦС-ыг төвийн сүлжээнд холбох ийм нөхцөл байдалтай байгаа. Үүнээс гадна ОХУ-аас бид нар өвлийн оргил ачааллын цагийн үеэр 345 Мвт-ын цахилгаан эрчим хүч импортолж байгаа. Түүнээс гадна 160 орчим мегаваттын хүчин чадалтай батареи хуримтлуурын станцууд бий. 245 Мвт-ын хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд төвийн бүсийн эрчим хүчний системд холбоотой байгаа. Ийм байна.

2 дахь асуулт техникийн нөхцөлийн хүсэлтийн талаар ярья. Цахилгаан эрчим хүчний тухайд бол төвийн бүсийн эрчим хүчний системээс цахилгаан эрчим хүч хүссэн, техникийн нөхцөл хүссэн өнөөдрийн байдлаар 3 мянган Мвт буюу 3 гегаваттын хүсэлтүүд ирчихсэн. Бид нар энийг бол техникийн нөхцөлийг олгож чадахгүй байгаа ийм нөхцөл байна.

Тавантолгойн цахилгаан станцыг барьснаар эдийн засгийн үр өгөөжийн талаар урьд нь их ярьсан. Одоо Оюутолгойн компани Гашуунсухайт-Ганцмод боомтоор цахилгаан эрчим хүч импортолж байгаа. Жилдээ 140 орчим сая долларын цахилгаан эрчим хүчийг бид нар Хятадын талаас энэ боомтоор худалдаж авч байгаа ийм байдалтай байгаа.

Тэц-3-ын талаар та бүхэнд танилцуулга өгье. 6 сарын 2-ны шөнө 00 цаг 19 минутад Тэц-3 дээр осол гарсан. 9 дүгээр турбины нөхцөл байдал хүндрэлтэй, эвдрэл гарсан. Засгийн газраас онцгой дэглэм тогтоогоод, бүрэн эрхт төлөөлөгч томилогдсон ажиллаж байна. Ослын шалтгаан нь эхнээсээ тодорхой болж эхэлж байгаа. Тагнуул, цагдаагаас үйл ажиллагаа явуулж байгаа ийм байдалтай явж байна. Тэц-3 дээр гарсан ослоос шалтгаалаад Улаанбаатар хотод 2 хүндрэл гарна. Эхнийх нь бол дулааны эрчим хүчний хүндрэл гарах ийм магадлал бий. 100 мегаватттай тэнцэх хэмжээний гига/килокалори цагтай тэнцэх хэмжээний ийм дулааны дутагдалд орох асуудлыг бид нар 2 шийдлээр нөхөх тооцоо гаргаад явж байна. 50 орчим мегаваттын гига/килокалори цаг хэрэглэгчийг бол Тэц-4 рүү болон Амгалан дулааны станц руу шилжүүлнэ. Үлдэж байгаа 50 орчим гига/килокалори цаг дулааныг бол нөгөө зуух нь гэмтээгүй байгаа учраас зуухыг нь цахилгаан дулаан хослон ажилладаг горимоос зөвхөн дулаан үйлдвэрлэдэг горим руу шилжүүлээд, энэ өвөлдөө бид нар ямар ч байсан 2025-2026 оны өвлийн оргил ачаалалд өнгөрсөн жилүүдэд байсан.../минут дуусав/

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд гүйцээж хариулъя. 5 номер.

Б.Чойжилсүрэн: Өнгөрсөн жилүүдэд хэрэглэж байсан дулааны эх үүсвэрийг бол хангана. Цахилгаан эрчим хүчний тухайд бол 50мвт-аар цахилгаан эрчим хүчний хомсдолд орно. Энийг бол Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 2 дугаар блок 150мвт-ыг ашиглалтад оруулах ийм төлөвлөгөөтэй явж байна. Шаардлагатай тохиолдолд Өвөр Монголын эрчим хүчний системээс 80 хүртэл мегаваттын цахилгаан эрчим хүчийг өвлийн оргил сарууд дээр дутагдалд орсон тохиолдолд импортлохоор холбогдох гэрээ, техникийн бүх болзлуудыг сунгасан. Түүнээс гадна ярьж байгаа. Сэлэнгэ аймгийн төв дээр явж байгаа 70мвт-ын хүчин чадалтай энэ ДЦС-ыг энэ 11, 12 сарын 1-ээс өмнө нэмж холбох ийм тооцооллууд дээр яваад, ямар ч байсан 2025-2026 оны өвлийн оргил ачаалалд бол цахилгаан эрчим хүч болон дулааны хувьд хязгаарлалт хийхгүйгээр давах ийм төлөвлөгөө боловсруулаад явж байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн. Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууна.

Ж.Алдаржавхлан: Эрчим хүчний энэ хуулийг дэмжихийг хүсэж байгаа. Чойжоо сайд аа, дэмжиж байгаа. Гэхдээ гадуур 1 хардлагууд байна. Тэрийг танаас шууд л шулуухан асуучихъя. Энэ хуулийг батлуулж аваад, тэгээд Худалдан авах ажиллагааны хуулиас гаргаад эрчим хүчний салбарын бүх тендер, худалдан авалтыг өөрийнхөө яам дээр аваачаад, улмаар Оюутолгой, Тавантолгойн станцын тендерийг хийх гэж байна гэсэн ийм яриа гадуур зөндөө байна. Энэ хардлагыг нэгд тайлж өгөөч.

2 дугаарт тэр тавхан хүнтэй комисс байгуулагдах юм байна шүү дээ. Энэ тоо энэ тэр нь арай цөөхөн биш үү. Ер нь юмыг олуулаа яривал буруугүй байдаг. Тийм учраас энэ комисс энэ тэрийг илүү өргөтгөж явбал сүүлд нь хэл ам багатай, хардлага багатай байх юм биш үү гэсэн ийм хоёр асуулт байгаа.

Ер нь зүгээр гадуур явж байгаа юмыг эртхэн асуугаад, сайн, муугаа хэдүүлээ юм эхлээгүй байгаа дээр мэдсэн нь зөв байх л гэж би бодож байгаа. Ер нь бол хуулийг бол би дэмжихийн төлөө байгаа.

Р.Сэддорж: Мандхай гишүүнийг асуулт дээр нэмье. Найдалаа гишүүнийг хасъя. Чойжилсүрэн сайд 5 номер. Ард иргэдэд тодорхой хариулаарай.

Б.Чойжилсүрэн: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Аливаа нэг хууль явахаар ийм гүтгэлгийн чанартай юмнууд явдаг. Одоо манай нийгмийн байгаа байдал энэ. Үүнээс бол тойрч гарах аргагүй. Гэхдээ танд тайлбар хэлье гэж бодож байна. Эрчим хүчний тухай хуулиар одоо бол ийм юм. Эрчим хүчний төсөл санаачлагч Эрчим хүчний яаманд өргөдөл гаргана. Өргөдлийг нь хүлээж аваад, бид нар ТЭЗҮ-ээ боловсруулаад ир гээд, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр оруулаад, дэмжсэн тохиолдолд Эрчим хүчний зохицуулах хороонд явуулаад, тусгай зөвшөөрлийг нь өгүүлээд, буцаад ирэхээр нь техникийн нөхцөлийг нь аль дэд станц дээр ямар нөхцөлөөр холбохыг нь гаргаж өгөөд, Диспетчерийн үндэсний төвтэй цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг байгуулаад, ажил эрхлэх зөвшөөрлийг өгөөд л явчхаж байгаа. Одоо байгаа хууль нь.

100 хувь төсвийн санхүүжилтээр хийх эрчим хүчний төслийг бол Тендерийн тухай хуулиараа явж байгаа. Энэ мөн ялгаагүй. Эрчим хүчний салбар дээр жишээлбэл манай салбар дээр хийсэн бол төсвийн ерөнхийлөн захирагч болгон өөр өөрийн салбар дээр хийсэн тендерийг зарладаг ийм л зохицуулалттай юм. Энэ дараагийн сэдэв болохлоор 100 хувь төр биш, 100 хувь хувь биш, хайбрид

санхүүжилт буюу тодорхой хэсэг нь төрийн санхүүжилт, тодорхой хэсэг нь хувийн хэвшлийн санхүүжилт оруулсан тохиолдолд эрчим хүчний тухай хуулиар тендер зарлах эрхийг авъя гэж энэ хуулийн төслийг санаачилсан. Тендер зарлах эрхийг Эрчим хүчний яам дээр зарлана. Дараа нь шалгарсан төсөл хэрэгжүүлэгчийг бол Засгийн газарт танилцуулна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль руу ороод, Засгийн газарт танилцуулаад ийм тендер зарлаад, ийм ялагч тодорлоо, гэрээ байгуулах эрх олгоно уу гэхээр Засгийн газар зөвшөөрөх юм бол бүх яамдаас санал аваад, Засгийн газрын тогтоол гаргаад, Эдийн засаг, хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд 2-т гэрээнд зурах эрхийг олгоно. Ийм зохицуулалтыг энэ хуулийн төслөөр оруулж ирсэн. Ийм байгаа юм.

Тэгэхээр тэр бүх эрхийг өөртөө шилжүүлж авлаа. 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулах юм гэж ярьж байгаа нь одоо байгаа тендерийн тухай хуулиар бүх төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрийнхөө тушаалаар үнэлгээний хороог байгуулдаг. Яг одоо байгаа тендерийн хуулийн заалтыг Эрчим хүчний хууль руу суугаад оруулсан. Гэхдээ нэг өөрчлөлт хийсэн. Одоо байгаа тэр 5-аас доошгүй байна гэдэг 1 заалт. 2 дугаарт нийт үнэлгээний хорооны гишүүдийн 40 хувь нь Эрчим хүчний яамнаас байна. 60 хувь нь ондоо байгууллагуудаас. Олон нийтийн төлөөлөл, бусад яамдаас байна гэдэг ийм заалтыг багасгаж оруулж ирж байгаа юм. Яагаад гэвэл эрчим хүчний энэ хуулиар Эрчим хүчний сайд дээр илүү эрх мэдэл очих гэдэг олон нийтийн хардлага гарч магадгүй гэдэг үүднээс ийм зүйлийг одоо байгаа Тендерийн хуулийн заалтыг Эрчим хүчний сайдын хувьд 40 хувь. Яагаад гэвэл Эрчим хүчний сайд өөрийн нөлөөллийн этгээдүүдээр бас янз бүрийн үнэлгээнд нөлөөлөх вий гэсэн хардлага гарах вий гэсэн үүднээс ийм заалтыг оруулж ирсэн. 60 хувь нь бол Эрчим хүчний сайдын харьяа хараат бус үнэлгээний хорооны гишүүд байна гэсэн ийм заалтууд оруулж ирсэн.

Тийм учраас таны яриад байгаа энэ хардлага бол та бол өөрөө хардаагүй байх. Хүмүүс хардсаныг надаас асууж байх шиг байна. Ор үндэсгүй зүйл гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Тодруулах юм уу. Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Ерөнхийдөө санааг ойлголоо. Тэр хайбрид санхүүжилт буюу төр, хувийн хэвшлийн хамтарсан төслүүд дээр л олон түмнийх гол хардах нь байгаа юм байна шүү дээ. Би бол хардаагүй шүү. Энэ хүмүүсийн хардаж байгааг танд дамжуулж, одоо энд асуучихаар хүн байхгүй байх шиг байна энийг хардаад. Тийм учраас би шулуухан асуучхаж байгаа юм. Тэгээд танд бас ажилд чинь хэрэг болох байх л гэж би бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна. Яах вэ, энэ хуулийг явуулахад 2 талтай л яригдаад байгаа л даа. Тэгэхдээ би бол бас хэт яг нэг талыг туйлширсан байдлаар бас хармааргүй байгаад байгаа юм. Яагаад гэхлээр ер нь эрчим хүчний салбар бол олон улсын жишигт хүрсэн ийм либералчилсан, хувийн хэвшлийг түлхүү дэмжсэн байдлаар оруулж өгөхөөр илүү давуу талтай. Ялангуяа энэ санхүүгийн хөрөнгө, санхүүгийн хэрэгслүүдийг бас түлхүү нэвтрүүлмээр байна. Бас яг хувийн хэвшлээр дамжуулаад шинэ ноу-хау технологиудыг нэвтрүүлэхийг хүсэж байна.

Дээрээс нь Засгийн газрын урт хугацааны санхүүгийн өр үүрдэг, эрчим хүч дээр өр үүрдэг асуудлыг илүү үр ашигтай болгох ийм боломж байгаа юм болов уу гэж харагдаж байгаа. Хувийн хэвшил орж ирснээрээ угаасаа хувийн хэвшил бол ашигт

ажиллагааг л харна. Тэгэхээр илүү Засгийн газрын янз бүрийн санхүүгийн төсөвлөлт, төлөвлөлтөөс илүү үр ашигтай байх талаас компаниуд орж ирэх нь давуу талтай байх гэж бодож байна. Тэгээд аль алиндаа хяналт тавиад явах учраас би бол зүйтэй байх гэж бодож, дэмжиж ярьж байгаа юм шүү.

Гэхдээ асуулт байгаа юм. Тодруулахгүй бол. Энэ хуулийн заалтыг яг ямар төслүүд дээр хэрэглэх гэж байгаа вэ гэдгийгээ бас тодруулаад өгөөч. Нэн тэргүүний ямар төслүүд байх вэ. Энэ заалтаар том чадлын олон станцыг өндөр тарифаар бариад, дараа нь төрд худалдах вий гэсэн ийм болгоомжлолууд бас яригдаад байгаа. Тэгэхээр энэ тариф нь ер нь хэд орчим байх вэ. Хязгаарлалт тавьж болох уу гэдэг асуулт байгаад байна.

3-д нь төрийн бодлогод тусгагдсан яг энэ төслүүд дээр энэ заалтыг хэрэглэнэ гэж төслүүдийн нэрийг, чадлыг нь тодорхой болгох юм бол яасан юм бэ гэсэн ийм 3 асуулт байна.

Р.Сэддорж: Хариулт 5 номер.

Б.Чойжилсүрэн: Мандхай гишүүнд дэмжиж байгаад баярлалаа. Эрчим хүчний либералчлал, эрчим хүчний шинэчлэлийг үргэлжлүүлээд хийхээс өөр аргагүй. Энэ магадгүй энэ либералчлал, энэ шинэчлэлийг хийхэд нэг Засгийн газрын бүрэн эрхийн хугацааг хүрэхгүй ч байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ бид нар аль болох хурдтай энэ либералчлал, шинэчлэлийг хийхийн төлөө ажиллана. Дэмжиж байгаа танд талархаж байна.

Ямар төслүүд дээр хэрэглэх гэж байна вэ гээд ингэхээр яг өнөөдрийн байдлаар манай Эрчим хүчний яам Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газрууд дээр төслийн ТЭЗҮ-д тендер зарлахад бэлтгэж байгаа хэд хэдэн төсөл байна. Эхнийх нь бол Тавантолгой цахилгаан станцын эхний 2 блок буюу 300мвт-ын цахилгаан станцын төслийг 2023 онд зарлаад, 2 оролцогч орж ирээд, харамсалтай нь маргасаар байгаад 2025 он хүртэл шүүхдэлцээд, энэ оны 1 дүгээр сар, 2 дугаар сардаа багтаагаад шүүхийн шийдвэр гарсан. Дахин зарлах утгатай ийм шийдвэр гарсан. Энэ төслийг 1 дүгээрт зарлана гэсэн ийм тооцоолол байна.

2 дугаарт Улаанбаатар хотын Тэц-2 станцын үнсэн сангийн байхад цэвэрлээд Тэц-5 гэж нэрлэж байгаа 300мвт-ын цахилгаан эрчим хүчний чадалтай, 360мвт-ын дулааны эрчим хүчний чадалтай энэ төслийг Улаанбаатар хот дээр тендер зарлах ажил бэлтгэл хийгдэж байна. 2 дахь төсөл нь.

3 дугаарт Багануур дүүрэг дээр Багануурын уурхайг түшиглээд жилдээ 600 мянган тонн хөх нүүрс буюу хагас кокс үйлдвэрлэх нүүрс химийн төслийг эхлүүлэх ийм ТЭЗҮ-ийг Эрдэнэс Монгол компани дээр хийж байгаа. Энийг явуулах болов уу гэсэн ийм тооцоолол бий.

4 дэх нь Дархан хотод дулаанаар 100 гига/килокалори цаг. цахилгаанаар 50 мегаваттын хүчин чадалтай ДЦС-ыг ашиглалтад оруулах ийм ТЭЗҮ боловсрогдоод явж байна. Энэ хууль батлагдчих юм бол энэ ондоо багтаагаад тендер зарлах гэсэн ийм тооцоололтой байна.

Түүний дараагийн төсөл бол Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот дээр 50мвт-ыг, Дархан дээр уучлаарай 200мвт-ын шүү. Нөгөө дулааны хүчин чадал. Даланзадгад дээр бол 100мвт-ын хүчин чадалтай дулааны. Цахилгааны хувьд бол

50мвт-ын хүчин чадалтай ийм ДЦС-ын ТЭЗҮ-д холбогдох төслийн бэлтгэл ажлууд хийгдээд явж байгаа. Та бүхэн энэ хуулийн төслийг батлаад өгөх юм бол эдгээр төслүүдийг явуулна.

Түүнээс гадна Багануур дүүрэг, Багахангай дүүрэг, Налайх дүүрэг гэх мэт орон нутгийн дулааны хомсдолтой байгаа ДЦС-уудыг бол нэмж барих ТЭЗҮ-үүдийг хийгээд явж байгаа. Иймэрхүү л ажлуудыг ямар ч байсан эхний ээлжид энэ жил, ирэх жилүүдэд хэрэгжүүлнэ гэсэн тийм тооцоолол баримжаатай явж байгаа гэдгийг хэлье.

Энэ төрд худалдан авах вий гэдэг ийм болгоомжлол ... /минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер үргэлжлүүлж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Урьд нь баригдчихсан байгаа, хувийн хэвшлийн хэрэгжүүлж байгаа том оврын цахилгаан станцуудыг төрд худалдан авах вий гэсэн нэг ийм гүтгэлэг, хардлагын чанартай зүйл олон нийтийн сүлжээгээр явж байх шиг байна. Тийм зүйл огт байхгүй. Энэ бол зөвхөн энэ мөчөөс яг хууль батлагдсанаас хойш хууль эргэж үйлчлэхгүй, хууль батлагдсанаас хойш хэрэгжих шинэ төслүүд дээр л холбоотой зүйл.

2 дугаарт одоо байгаа хувийн хэвшлийн энэ станцыг төрд худалдан авах ийм боломж байхгүй. Тендерийн тухай хууль болон Төсвийн тухай хууль, бусад хуулиудаар энэ хориотой заалт гэдэг ийм тайлбар хэлье.

Тариф бол ийм байна. Зөвхөн уурхайн ам дээр баригдаж байгаа дулааны станцуудын тухайд. Бөөрөлжүүтийн цахилгаан станцын цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээг 2016 оны 3 сард хийсэн юм байна лээ. Эхний жилдээ 7 центр 2 дахь жилээсээ 28 .../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут 5 номер.

Б.Чойжилсүрэн: 2-28 дахь жилүүддээ бол 1квт цаг эрчим хүчний үнийг төвийн эрчим хүчний системд холбогдохдоо 8,95 центээр холбогдоно гэсэн ийм гэрээтэй юм байна лээ.

Тэр Баян сум дээр 660мвт-ын цахилгаан станц явж байгаа. Энэ бол төвийн бүсэд эрчим хүчний системд нийлүүлэх үнэ нь 8,4 цент байгаа. Сэлэнгэ аймгийн төв дээр байгаа 70мвт-ын цахилгаан станцын төсөл 8,4 цент, Тосонцэнгэл дээр байгаа ДЦС-ын цахилгаан эрчим хүчний сүлжээнд нийлүүлэх үнэ нь бол 8,4 цент дээр байгаа ийм л байдалтай байгаа.

Дахин давтан хэлье. Урьд нь хэрэгжүүлж байгаа хувийн компаниудын хэрэгжүүлж байгаа төслийг төрд худалдан авах бололцоо энэ өргөн барьсан хуулийн төслүүдээр бий болохгүй.

Р.Сэддорж: Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Асуух гэж байсан асуултууддаа хариулт авчихлаа л даа. Би үг хэлээд, 1 асуулт асууя. Энэ эрчим хүчний асуудал бол олон жил угширсан асуудал л даа. Ганцхан Чойжилсүрэн сайдын үед бий болчихсон асуудал бол биш. Тэгээд би бас тийм нэг зүйлийг хэлье. Бас залуу гишүүд мэдэхгүй байж магадгүй. Ерөнхий

сайд Чойжилсүрэн гишүүн би Эрчим хүчний сайд үргэлжлүүлж хиймээргүй байна. Миний нэр нүүр бүүр янз янзын байдал үүслээ. Юу гэдэг юм байгаа юм. Би үгээр нь хэлж чадахгүй байна. Тэгээд Ерөнхий сайдын зүгээс Чойжилсүрэн сайдыг энэ бэрхшээлүүдийг даван туулахад та ажлаа үргэлжлүүлж хийх шаардлагатай гэдгийг хэлж байсан юм. Та энэ зүйлүүдийг даван туулах, бүх л зүйлүүдийг даван туулах хүн нь Та. Таны нэр нүүр яах вэ, төрийн ажил чухал байна. Энийгээ үргэлжлүүлж хий. Танаас өөр хүн бол энийг хийхгүй. Хууль яриад хойшоо суучихна гэж яг ийм үг хэлж байсан юм. Тэгэхээр та бол хууль яриад хойшоо суухгүй, ажлыг урагшлуулъя гээд зүтгэж байгааг би бас маш сайн дэмжиж байгаа. Зарим зүйл дээр би бол Чойжилсүрэн сайдтай санал нийлдэггүй. Уучлаарай санал нийлдэггүй. Зарим зоригтой, зоригтой саналууд дээр би бол үнэхээр дэмждэг. Тэр Улаанбаатар хотын түлшний асуудал ч гэсэн бол үнэхээр тэгж шийдэхээс өөр аргагүй бол туршиж үзэхээс өөр арга байхгүй шүү дээ. Ганцхан Чойжилсүрэн сайд л балбуулсаар байгаад л дууссан. Тэгээд ямар ч гаргалгаа ярихгүй хүмүүс. Тэгээд л шүүмжлээд л байна. Тэгэхээр өнөөдрийн асуудал дээр бол Чойжилсүрэн сайдын гаргаж байгаа энэ гаргалгаа бол энэ цаг үедээ нийцсэн гаргалгаа л гэж би үзэж байгаа юм. Тийм учраас энэ бодлогыг дэмжээд явуулах нь зөв. Өөр гаргалгаа байна уу. Бид нарт энэ асуудлыг ингэж хурдан хурдан шийдвэрлэж явахгүй, тэгээд л шүүх дээр очоод гацчихдаг, бүх юм нь удааширдаг бол тэгээд хэн хожих юм. Энэ намар тэгээд бид яах юм. Тэгээд хүмүүсийн хүссэнээр бид энэ намар аягүй бол тэгээд л дулаан, цахилгаангүй сууж байх уу. Зарим хүмүүс баярлах нь байна шүү дээ. Тэгээд төрийн алба, Их Хурлын гишүүд бол энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Бүх юмыг ард иргэдэд таалагдана гэдэг байдлаар биш, асуудлыг шийдвэрлэх гэж байх ёстой. Одоо биржийн тухай хууль бол тухайн үедээ олон сайдын шүүмжлэлийг дагуулсан. Олон юмаар гүтгүүлсэн. Машин тэрэг явуулдаг олон хүмүүс бараг заналхийлсэн шүү дээ. Тэгж байгаад батлагдсан. Тэгээд үр шим нь хүртсэн. 2 машин явуулж байсан, 5 машин явуулж байсан бүх хүн над руу дайрсан, хараасан, ерөөсөн. Тэгэхдээ би бол эрчим хүчний салбарт бол Чойжилсүрэн сайдын хийж байгаа шинэчлэлийг 100 хувь дэмжиж байна. Би Чойжилсүрэн сайдыг 1 жижигхэн юмны төлөө, жижигхэн амбицын төлөө 1 жижигхэн юу гэмээр юм, тэрийг ингэчихье, энийг .../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Хараад ч байх юм байхгүй байна л даа. Итгэж байгаа. Тийм учраас энэ улс орны өмнө тулгамдаж байгаа асуудлыг хурдан шийдвэрлэх хэрэгтэй. Энэ нөгөө Тэц-2 дээр билүү, Тэц-3 дээр үүсчихсэн байгаа асуудал энэ зундаа шийдэгдчих юм байгаа биз дээ. Энийг бол та хариулаад байх шиг байна лээ. Би зүгээр баталгаажуулж ахиж асууж байгаа юм. Тэц-3 нь билүү, Тэц-2 нь билүү би санахгүй байна. Тэгээд энэ асуудал 100 хувь шийдэгдээд, намар хэвийн байдалдаа орчих юм байгаа биз дээ гэдэг дээр асуулт асууя.

Тэгээд хуулийг дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье. Баярлалаа.

Р.Сэддорж: 5 номер.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар гишүүнд ойлгож, дэмжиж байгаад талархал илэрхийлье. Тэц-3 дээр үүссэн нөхцөл байдал харамсалтай нөхцөл байдал үүссэн. Эрдэнэт хүний амь эрсэдсэн. Олон арван тэрбум төгрөгийн хохирол учруулсан. Энэ асуудлыг Засгийн газар дээр онцгой дэглэм тогтоогоод, Засгийн газраас Бүрэн эрхт төлөөлөгч томилогдоод, энэ ажил хийгдэж байна. 2025-2026 оны өвлийн оргил ачаалалд Тэц-3 дээр бас үүссэн энэ чадлын дутагдлуудыг бүрэн шийдвэрлэж дуусгана.

Р.Сэддорж: 1 юм асуугаадахъя. Бид одоо яг эрчим хүчний хэдэн хувийг гаднаас авч байна вэ. Хэдэн хувиа дотооддоо үйлдвэрлэж байна вэ. Одоо дотоодын эрчим хүчний мэргэжилтнүүдийн чадавх дэлхийн аль түвшинд явж байна. Одоо ер нь хангалттай болчихсон уу. Бид бол хямд эрчим хүч үйлдвэрлэх бүрэн боломжтой нүүрсний, нар салхины асар их нөөцтэй ийм орон. Тэгэхээр бид одоо алийн болгон дотооддоо эрчим хүчээ үйлдвэрлээд, ажлын байраа бий болгох ийм боломжтой байтал гаднаас ингээд амарчилж авдаг юм уу, яаж авдаг юм байнга л гаднаас авч байгаа. Одоо урд боомтуудаар, бүх боомтуудаар л авч байна. Тэгээд энэ дээр Эрчим хүчний яам бол бүрэн хүсэл зоригтой байгаа юу. Энэ импортын товыг багасгах талаар, энэ тал дээр та тодорхой хэлж өгөөч.

Тэгээд 2 дугаарт нь тэр 10 аймаг дээр барьж байгаа цахилгаан станцууд санхүүжилт нь зогссон гэж би сонссон. Энэ тийм харамсалтай зүйл болсон уу. Эсвэл ажил нь зүгээр үргэлжилж байгаа юу: Ийм асуулт байна. 5 номер.

Б.Чойжилсүрэн: Сэддорж даргын асуултад хариулъя. Нийт өнгөрсөн жил 11 тэрбум квт/цаг эрчим хүч түгээсэн. Үүнийхээ 70 орчим хувийг нь дотоодын үйлдвэрлэлээс 30 орчим хувийг нь импортоор хангасан. 3 том боомтоор эрчим хүч импортолж байна. Эхнийх нь Гашуунсухайт-Ганц мод боомтоор Оюутолгой компани болон тэр орчмын Өмнөговь аймгийн иргэд цахилгаан эрчим хүч хэрэглэж байгаа нь дунджаар Оюутолгойн 140 сая, бусад хэрэглэгч нарт нийлээд 145 орчим сая долларын импорт хэрэглэж байгаа.

2 дугаарт ОХУ-аас Сэлэнгийн райоонаар 220 киловольтын хос шугамаар 345мвт хүртэл хүч чадалтай эрчим хүч импортолж байгаа. Энэ өнгөрсөн 2024 оны хэрэглээ 1 тэрбум квт/цаг хүрсэн. Ойролцоогоор 60 орчим сая долларын импорт хэрэглэж байгаа.

3 дахь том хэрэглээ бол баруун бүсийн эрчим хүчний систем. ОХУ-ын Алтайн хязгаараас бид нар бас импортолж хэрэглэж байгаа. 200 гаруй сая квт/цаг эрчим хүчийг бол импортолж байгаа ийм байдалтай. Энийг бид нар гадаадад жил болгон алдаж байгаа валютын урсгалыг дотооддоо үлдээе, чадлын дутагдлаас гаръя гэдэг ийм зорилтыг Эрчим хүчний яам тавиад явж байна. Жишээлбэл Оюутолгойн станцын хэрэглээг бол бид нар Тавантолгойн цахилгаан станцыг барьчих юм бол энэ 145 орчим сая долларын импортыг жил болгон цахилгаан эрчим хүчний импортыг бид нар дотоодоос хангах нэг бололцоо бүрдэнэ.

2 дугаарт Төвийн бүсийн эрчим хүчний систем дээр саяын нэр дурдсан төслүүд болон Тэц-5 маань ашиглалтад орчих юм бол жил болгон 60 орчим сая долларын цахилгаан эрчим хүч төвийн бүсээр импортолж байгааг зогсооно.

Баруун бүсийн эрчим хүчний систем дээр Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц ажил нь явж байна. Гацаж гацаж явсаар байгаад ямар ч байсан өнгөрсөн жилийн намраар гацаанаас гараад ажил нь урагшлаад явж байна. 2029 оны эхний хагаст ашиглалтад орох болов уу гэсэн ийм тооцоололтой явж байгаа. Ингэсэн тохиолдолд бол нийт цахилгаан эрчим хүчнийхээ 99 орчим хувийг л бид нар дотоодоос хангана. 100 хувь хангана гэх юм бол Говь-Алтай аймгийн Алтай сум гэх мэт жижиг боомтууд, Ховдын Булган гэх мэт энэ боомтуудыг дотоодоос хангахаар хэт үр ашиггүй болж байгаа учраас жижиг боомтуудыг бол магадгүй энэ хөрш улсуудаасаа бол импортлох болов уу гэсэн ойрын хугацаандаа ийм тооцоолол бий. 300, 400км ЦДАШ татахаар эхний хөрөнгө оруулалтын зардал шугамын алдагдал гээд ерөөсөө импортолсноосоо өндөр үнэтэй гарчихсан ийм тооцоо бий. Тэгэхээр 100 биш гэхэд

99 хувьтай цахилгаан эрчим хүчний хувьд бол дотоодоосоо хэрэглээг хангана гэсэн ийм л тооцоолол байгаа.

Р.Сэддорж: Өөр хариулах хүн байна уу. Сууж байгаа хүмүүсээс. 5 номер.

Б.Чойжилсүрэн: Сэддорж даргын асуултад дутуу хариулсан байна. Энэ 10 аймгийн дулааны станцын төслийг Солонгосын Экзим банк Монгол Улсын Засгийн газар хооронд гэрээ хэлэлцээр хийгдээд, хөнгөлөлттэй эх үүсвэр хэрэгжүүлээд явсан байна. 2021 онд тендер зарлаад, 3 удаа зарлаад 3 дахь дээр нь Солонгосын “Бюксан инженеринг” гэдэг компани орж ирээд гэрээ байгуулаад явж байсан. 2026 оны 5 сарын 31-ний өдөр ашиглалтад өгч дуусгана гэдэг ийм төлөвлөгөөтэй явж байсан чинь сая өнгөрсөн 4 дүгээр сард харамсалтай зүйл болж энэ төслийг хэрэгжүүлж байсан “Бюксан инженеринг” компани дампуурлаа зарласан. Солонгосын Дампуурлын тухай хуулиар шүүхийн шийдвэр гарна. Бүрэн эрхт төлөөлөгч томилогдоно. Энэ томилогдох бүрэн эрхт төлөөлөгч тэр компанийн хэрэгжүүлж байсан төслүүдээс алийг нь үргэлжлүүлээд хэрэгжүүлэх вэ, алийг нь зогсоох шийдвэр гаргадаг юм байна. Энэ шийдвэр 5 сард хуралдах байсан шүүх хуралдаан .../минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер гүйцэж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Солонгосын захиргааны хэргийн шүүхийн хуралдаанд 5 сарын 18-нд 1 товлогдоод, 6 сарын 24-нд 1 хойшлогдоод, одоо 7 дугаар сард шийдвэр нь гарна гэсэн ийм байдалтай. Энэ шүүхийн шийдвэр гарсны дараа Кореа экзим банк Монгол Улсын Засгийн газар хооронд энэ төслийг яаж цаашаа үргэлжлүүлэх вэ, эсвэл одоо байгаа хэмжээнд нь үнэлээд, шинэ тендер зарлах уу гэдэг энэ асуудлыг 1 талдаа гаргаж шийдэх байх.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Цэнгүүн гишүүнээр тасалъя. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Энэ хавар гурилын гаалийн импортын татварыг буцааж сэргээх асуудал Их Хурлаар орж ирсэн. Тэгээд буцсан. Тэгээд буцсан шалтгаан нь бол тэр дагалдах тогтоолын төсөл нь хамт орж ирээгүй бас нөлөөлсөн гэж би бол хувьдаа үздэг. 2 талцсан энэ дээр. Гурилын хувьд дотоодын үйлдвэрлэлээ дэмжих нь зөв өө, тариалалтаа дэмжих нь зөв. Зөв. Нөгөө талдаа ард иргэд хямд үнэтэй гурил орж ирэх ёстой. Импортын гурил энэ дотоодын гурилын үнийг тогтворжуулахад өрсөлдөөн үүсгэж, зөв зүйтэй боллоо гэдэг нэг хэсэг байсан.

Тэгэхээр эндээс хамгийн сүүлд ямар шийдэл гарсан гэхээр Төсвийн байнгын хороо дээр тогтоолын төслийг миний бие санаачилсан. Тэгээд энэ чуулган дээр дэмжигдээд, тэгээд хамгийн сүүлд орж ирэхдээ Төсвийн байнгын хороо энийг хамт оруулж ирээгүй. Өөрөөр хэлбэл тэнд тодорхой болзолтойгоор энэ гурилын импортын татварыг буцааж сэргээхийг дэмжье гэдэг ийм агуулгатай тогтоол байсан. Дахин гурилын импортын татвартай холбоотой хуулийг өргөн мэдүүлэхдээ энэ тогтоолыг үнэнд гүйцэгдэж оруулж ирсэн. Ямар утгатай тогтоол байсан гэхээр үгсэн хуйвалдаж гурилын үйлдвэрүүд үнээ үндэслэлгүйгээр нэмснийг эрх бүхий байгууллага тогтоосон тохиолдолд Засгийн газар яаралтай горимоор дахиад гурилын татварыг тэглэх ийм хуулийн төслийг оруулж ирнэ гэдэг ийм утгатай тогтоол байгаа.

Тэгэхээр би яг үүнтэй адилхан Эрчим хүчний энэ хууль дээр тодорхой зүйлүүд дээр нь болзол хязгаар, тааз түгжээ тавиад, энэ хуулийг дэмжээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Тэгэхгүй бол эрчим хүчний асуудал тулгамдсан асуудал мөн. Яг гурилын үнэ өсөх вий гэдэг ард иргэдэд байдаг тэр болгоомжлолтой адилхан, хангамж хүрэлцэхгүй яах вий, дутагдалд орох вий, үнэ нь нэмэгдэх вий, зогсох вий гэдэг айдас байгаа. Тийм учраас би тодорхой санал хэлж байгаа. Энийг хэрвээ Байнгын хороо, Их Хурлын чуулганаар хэлэлцэх тохиолдолд энэ хууль тогтоомж дээр Өрийн удирдлагын тухай хуульд байдаг нийт Монгол Улсын ДНБ-ий 60-аас илүү хувьд нь өр тавьж болохгүй гэдэг ийм утгатай заалт байгаа. Яг үүнтэй адилхан энэ 1600-1700 орчим манай хэрэглээний тодорхой хувьд нь Засгийн газар баталгаа гаргах түншлэлийн гэрээ байгуулах асуудал байна гэдэг энэ таазыг л заагаад өгөх хэрэгтэй. Ингэх юм бол энэ гишүүдийн, ард иргэдийн болгоомжлоод байгаа энэ үнэхээр тэр төр, хувийн хэвшлийн түншлэлээр замбараагүй олон газартай гэрээ байгуулах гээд байна уу гэдэг асуудал цэгцлэгдэнэ гэж үзэж байгаа. Ер нь төр гэдэг чинь ийм хэм хэмжээ тогтоож, тодорхой зохицуулалт хийж зах зээлийн эдийн засагт явахгүй бол болохгүй шүү дээ. Бүх зүйлд нээлттэй, ил тод боломжийг олгох хэрэгтэй. Харин боломж олгосоор байтал тодорхой болзолтойгоор нөхцөлийг нь бүрдүүлж өгсөөр байтал биелүүлэхгүй бол харин хатуу хариуцлага тооцдог байх ёстой гэж ийм зарчмын саналтай байгаа юм.

Тэгэхгүй бол бид нар дахиад л и энэ маргаанаа яриад, эрчим хүчний асуудлаа яриад байх вий. Тийм учраас энэ зүйлийг бол энэ агуулгаар нь тусгах нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгэх юм бол энэ бүх зүйл цаашаа эдийн засгийн чөлөөт өрсөлдөөний зарчмаараа явна. Энэ дээр нь бол энэ боломжийг хууль дээрээ бүрдүүлж өгөх нь зүйтэй л гэж үзэж байгаа юм. Тэгэхгүй бол ингээд сөрөг үр дагаврууд бол гарна шүү. Өөрөөр хэлбэл 300мвт-ад тогтворжуулалтын буюу тодорхой өндөр үнэтэйгээр авах, төр, хувийн хэвшлийн түншлэлээр станц ажиллаж байгаа юм байна. Цаашдаа энийг хэдэн мегаваттад өгөх юм гэдэг энэ таазыг л хэрэглээнийхээ болон тодорхой хувиар тогтоогоод өгнө.

Харин экспортын чиглэлтэй эрчим хүчний үйлдвэрлэлийг бол бүх талаар дэмжээд явах нь зүйтэй.

Р.Сэддорж: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Эрчим хүчний салбарт бол нэг зүйл маш товч бөгөөд тодорхой байгаа. Юу гэхээр эрчим хүчний эх үүсвэрүүдийг олноор барьж байгуулах зайлшгүй шаардлагатай байгаа. Гэтэл одоо хуулийн өөрчлөлтүүдээс болоод ялангуяа төр, хувийн хэвшил хамтраад хийх эх үүсвэрүүдийг барихад саад тотгор учраад байгаа учраас энэ Эрчим хүчний хууль дээр тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг оруулаад энэ төслүүдээ яаралтай явуулъя гэдэг ийм заалт оруулж ирж байгаа. Салбараа бол би 2 гараа өргөөд дэмжиж байгаа.

Гэхдээ мэдээж нөгөө энэ заалтууд маань мэдээж олон эрсдэлийг бол дагуулах юм байна гэдгийг нийгэм ч ярьж байгаа, мэргэжилтнүүд ч ярьж байгаа, салбарууд ч ярьж байгаа. Тухайлбал юу гэдэг юм энэ заалтыг ашиглаад том чадалтай, тэгээд өндөр тарифтай тийм эх үүсвэрийг өндөр үнээр бариад, тэгээд төрд худалдчих, шилжүүлчих гээд байгаа юм биш үү. Энэ нь цаашаа нөгөө бид нарын өрсөлдөөнд зах зээлийг бий болгоход саад тотгор учрах юм биш үү. Дээрээс нь энэ станцуудыг шалгаруулах гээд байгаа тэр 5 хүн чинь нөлөөлөлд өртчих юм биш үү гээд маш олон эргэлзээтэй ийм асуултууд болон эрсдэлүүд байгаад байгаа.

Тийм учраас энэ хууль дээрээ тэр эрсдэлүүдийг хаах хаалтуудыг буюу өөрөөр хэлбэл сая Чойжилсүрэн сайд хэллээ. Тодорхой хэмжээний яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай төслүүд байгаа. Эдгээр маань бүгд манай улсын төлөвлөгөөнд бол орчихсон байдаг. Тэгэхээр яг энэ төслүүдийг хэрэгжүүлнэ гэсэн жагсаалтыг нь, дээрээс нь хүчин чадлыг нь, дээрээс нь энэ тендер зарлахдаа дээд үнэ буюу дээд тариф нь тэрнээс доош бол шалгаруулах ёстой ч гэдэг юм уу, дээрээс нь хамгийн гол чухал юм нь цаашдаа бид нар өрсөлдөөнт зах зээлд ороход энэ эх үүсвэрүүд маань өрсөлдөөний байдлаар бол үнээ тохироод зах зээлдээ ороод явна ч гэдэг юм уу ийм заалтуудыг, ийм эрсдэлүүдийг хаах заалтуудыг оруулж өгөөд, тэр хууль дагасан тогтоол ч юм уу тэр байдлаар ингээд гаргаж өгөөд цаашаа явбал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Бусдаар бол гол чухал бид нарын өмнө тулгараад байгаа зүйл бол ерөөсөө л эх үүсвэрүүдээ барих зайлшгүй шаардлагатай байгаа. Гэтэл бусад хуулиуд маань энэ ажлуудыг явуулахад саад тотгор байгаа учраас ийм юмнууд орж ирж байгаа. Тэгэхдээ нийгэм болон энэ улс төрчид, бусад хүн, мэргэжилтнүүд нь хардаж байгаа нь бол зөв. Тийм учраас тэр хардаж байгаа, тэр үүсэх гээд байгаа гэсэн эрсдэлүүдийг бид нар тооцож үзээд, тэгээд тэр эрсдэлүүдийг хаах юмыг бол хийгээд явах нь зүйтэй байх. Тэгэхээр тусгай ажлын хэсэг гаргаад, тэр ажлын хэсэг маань хууль боловсруулсан хүмүүстэйгээ хамт суугаад, эрсдэлүүдийг хаах тэр түгжээнүүдийг тэр тогтоолдоо, тэр хуульдаа оруулаад, тэгээд энийгээ цаашаа явуулаад, тэгээд Чойжилсүрэн сайд түрүүнд бас танилцуулсан. Магадгүй энэ хууль маань нэг тодорхой хугацаатай 1 жил ч юм уу, 2 жил ч юм уу эсвэл Тендерийн хууль болон Төр, хувийн хэвшлийнхээ түншлэлийн хууль дээр өөрчлөлт оруулах хүртэл хүчинтэй ч гэдэг юм уу ийм ийм заалтуудаа оруулж өгөөд, цаашаа явуулаасай гэсэн ийм саналтай байна.

Р.Сэддорж: Цэнгүүн гишүүн хассан. Ажлын хэсэг байгуулах санал гарч ирж байна. Жагсаалт гаргах санал гарч ирж байна. Ерөөсөө энэ эрчим хүчний салбар бол энэ бүх Улсын Их Хурлын гишүүдийн анхаарал хандуулах ёстой, тулгамдсан салбар учраас бүгд тодорхой хэмжээнд мэдэж байгаа. Тэгээд их гайхдаг. Энэ гайхсан эргэлзээнүүд, танай салбарын зовлонг үүгээр ингээд шийдэх энэ хугацаа ирчихсэн байна л даа. Энийг бас Энхцэцэг гишүүний үгэн дээр нэмж хэлье.

Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Монгол Улс бол эрчим хүчний шавхагдашгүй их нөөцтэй улс орон билээ. Нүүрс, нар, салхи, ус. Тийм ч учраас Монгол Улс бол эрчим хүчний салбарт тусгаар тогтнолоо хадгалах, аюулгүй байдлаа хадгалах, цаашлаад экспортлогч орон болох зорилтыг бол Ардчилсан намын үе үеийн мөрийн хөтөлбөрт бол тусгасан байдаг. Эрчим хүчний салбар бол эдийн засгийн өсөлтийг тэтгэх, аж үйлдвэрийг хөгжүүлэх үндсэн бас суурь байдаг. Энэ утгаараа ч Ардчилсан нам засаглаж байх цаг хугацаанд бол эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, тодорхой бодлогууд бол хэрэгжүүлж ирсэн. Харамсалтай нь өнгөрсөн 9 жилийн хугацаанд бол эрчим хүчний салбарт бас дорвитой бүтээн байгуулалтууд төдийлөн хийгдсэнгүй. Тэр утгаараа ч тэр эрчим хүчний салбарын аюулгүй байдал бас алдагдаж байгаа нөхцөл байдал үүсэж байна.

Тэр утгаараа бид сая Монгол Улсын Ерөнхий сайд шинээр томилогдоход Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс тодорхой бодлогын шаардлагыг хүргүүлсэн байгаа. Энэ шаардлагад бол 2025-2026 оны өвөл цахилгаан дулаан

хангамж дутагдах эрсдэлээс сэргийлэх, салбарын реформыг бодитоор хэрэгжүүлэх замаар эрчим хүчний хараат байдлыг бүрэн халах гэсэн зүйл заалтыг бол тусгасан.

Засгийн газраас тун яаралтай байдлаар эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан. Энэ хуулийн төсөлд бол анхаарал татаж байгаа зүйлүүд бол эрчим хүчний салбарын суурь харилцаануудыг бол бас өөрчилж байна хуульд өөрчлөлт оруулах замаар. Тэр утгаараа Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг энэ асуудал дээр байр сууриа нэгтгэх шаардлагатай гэж үзэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу 5 хоногийн завсарлага авахыг Эдийн засгийн байнгын хорооны дарга, хурал даргалагчаас хүсэж байна.

Р.Сэддорж: Хуралдаанаас завсарлага авах Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тухай хууль нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын 5-аас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг 1 удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно гэсэн ийм заалттай байна.

Ингээд Ардчилсан намын бүлгийн дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн гаргасан саналаар гэхдээ энэ чинь дахиж бүлгүүд бас хоорондоо зөвшилцөж болно. Тийм ээ Жаргалан гишүүн ээ. Энэ хугацаа бол заавал 5 байх, наана нь хугацааг зогсоож болно. Тэгж ойлгож болно тийм үү.

12.6.завсарлага авсан ном эвслийн бүлэг завсарлагын хугацааг уг хугацаанаас өмнө дуусгавар болгож, тухайн асуудлыг хэлэлцүүлэх санал гаргаж болно гэж заасныг бас энд тодруулж хэлье.

Ингээд завсарлага авч байна. 5 хоногтоо л авчихъя. Тэгээд тэрнээс наана нь дахиад 2 бүлгүүд хуралдах байх.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаан хаасныг мэдэгдье.

13.08 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ